



**ХЭНТИЙ АЙМГИЙН
МӨРӨН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2025 оны 05 сарын 08 өдөр

Дугаар 5/11

Мөрөн сум

**Г.Дашмааг түр орлон гүйцэтгэгчээр
томилох тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.5 дахь хэсэг, Төрийн албаны тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1.9, дахь заалт, 43 дугаар зүйлийн 43.3.3 дахь заалт Засгийн газрын 2019 оны 09 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1.Засаг даргын Тамгын газрын Төрийн сангийн мэргэжилтэн (Г.Дашмаа)-г Засаг даргын Тамгын газрын Санхүү албаны дарга бөгөөд төсвийн ерөнхий нягтлан бодогчийн орон тоо нөхөгдөх хүртэл Засаг даргын Тамгын газрын Санхүү албаны даргын түр орлон гүйцэтгэгчээр томилсугай.

2.Санхүү албаны дарга бөгөөд төсвийн ерөнхий нягтлан бодогчийн хуулиар хүлээсэн эрх, үүргийг хэрэгжүүлж, хариуцлагыг бүрэн хүлээж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын Төрийн сангийн мэргэжилтэн (Г.Дашмаа)-д үүрэг болгосугай.

3.Санхүү албаны дарга бөгөөд төсвийн ерөнхий нягтлан бодогчийн түр орлон гүйцэтгэгчээр томилогдсон Засаг даргын Тамгын газрын Төрийн сангийн мэргэжилтэн (Г.Дашмаа)-д үндсэн цалингийн 40 хувиар тооцож цалинжуулахыг Засаг даргын Тамгын газрын нягтлан бодогч (Б.Нандин-Эрдэнэ)-д зөвшөөрсүгэй.

4.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, ажил хүлээлцэх комисс томилон ажиллуулахыг Засаг даргын Тамгын газрын дарга (Н.Намжилноров)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Н.ХАТАНБААТАР

